



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2021 оны 05 сарын 20 өдөр

Дугаар 174

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө акталж, данснаас хасах зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 6.2.1, 6.4.3, 6.4.4, 6.5 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Булган-А33А” төрийн өмчит хувьцаат компанийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн, 11 нэрийн, нийт 10,706,721.45 (арван сая долоон зуун зургаан мянга долоон зуун хорин нэгэн төгрөг дөчин таван мөнгө) төгрөгийн балансын үнэ бүхий хавсралтад заасан хөрөнгийг акталж, данснаас хасахыг зөвшөөрсүгэй.

2. Зам, тээврийн хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга С.Батболд, “Булган-А33А” төрийн өмчит хувьцаат компанийн гүйцэтгэх захирал Э.Пүрэвдэмбэрэл нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Үндсэн хөрөнгийг акталж, данснаас хасах, устгах, сэлбэгээр орлогод авах ажлыг холбогдох хууль тогтоомж, захиргааны актын дагуу өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.3. Арга хэмжээний биелэлтийг 2021 оны 2 дугаар улиралд багтаан ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.


ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2021 оны 05 дугаар сарын 20-ны өдрийн
дугаар тогтоолын хавсралт



**"Булган-АЗЗА" төрийн өмчит хувьцаат компанийн үндсэн хөрөнгөд
бүртгэлтэй акталж, данснаас хасах хөрөнгийн жагсаалт**

д/д	Хөрөнгийн нэр	Ашиглалтад орсон он	Тоо хэм жээ	Балансын үнэ, хуримтлагдсан элэгдэл /төгрөг/
1	Асфальто зүсэгч хөрөө	2009	2	1,849,026.00
2	Бетон зуурагч	2012	2	2,100,000.00
3	Гагнуурын аппарат	2012	2	929,125.00
4	Дуран /нивилер/	2010	1	1,336,425.00
5	Камер	2016	1	750,000.00
6	Проектор	2016	1	863,545.45
7	Төхөөрөмж NP-10	2016	2	480,000.00
8	Хэвлэгч	2016	2	300,000.00
9	Цахилгаан үүсгэвэр	2016	1	500,000.00
10	Цахлгаан үүсгүүр	2010	1	870,000.00
11	Өсгөгч пульт микрофон	2016	1	728,600.00
	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН			10,706,721.45 (арван сая долоон зуун зургаан мянга долоон зуун хорин нэгэн төгрөг дөчин таван мөнгө)